

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨРИЙН
АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025.09-15

Сайншанд

Хөтөлбөрийн зорилго: Нийт ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гэрээний дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох үүднээс нийгмийн баталгааг нь хууль тогтоомжийн хүрээнд хангах, гадны аливаа нөлөөллөөс хамгаалах, дэмжлэг үзүүлэх, ажиллах нөхцлийг зохих стандартын дагуу хэрэгжүүлэхэд оршино.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь
1	2	3	4
1	1.1 Ажлын байрны дотоод, гадаад орчинг сайжруулж шинэчилсэний үндсэн дээр төрийн албан хаагчийн эрүүл байх зохистой нөхцлийг бүрдүүлэх.	1.1.1. Байгууллагын ойр орчимд цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх, мандлын цэцгээр гадна талбайн өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор байгууллагын хашаанд улиас, агч зэрэг 40 ширхэг мод, цэцгийн суулгац авч цэцгийн мандалд тарьсан, байгууллагын гадна хашааг зүлэгжүүлсэн. 1.1.2. БОУАӨЯмнаас төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэхэд нь зориулж 4 ширхэг мотоциклоор хангасан. 1.1.3. Төвийн даргын өрөөний шалыг паркетан шалаар сольж, 8 ширхэг гэрлийг суурилуулан ажлын байрны дотоод орчинг сайжруулсан. 1.1.4. Байгууллагын албан хаагчдыг ажлаа хийнгээ хүүхдээ харах боломжоор хангаж “Хүүхдийн өрөө”-ний дотор заслыг хийж гүйцэтгэсэн. Үүнд 25м/кв-д өрөөг хулсан хавтангаар хана хийж дулаан алдагдалтыг бууруулсан. Мөн шалны хүрээ, 10м/кв-д лампиран тааз хийж, 2 ширхэг том нүдэн гэрэл хийсэн. 1.1.5. Урсгал засварт 2025 онд нийт 20,705,400 төгрөгийн төсөв батлагдсан. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор өрөө тасалгаа, станц, хашаа зэрэгт урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. 05 дугаар сарын байдлаар 7,721,200 төгрөгийг урсгал засварын ажилд зарцуулсан байна.	100

1	2	3	4
2	2.1 Албан хаагчдыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор жилд нэг удаа эмнэлгийн үзлэгт хамруулах, үүнтэй холбогдон гарах зардлыг урсгал зардлаас гаргах.	2.1.1. Улс орон даяар хэрэгжиж байгаа Эрт илрүүлэг эрүүл мэндийн оношилгоо багц үзлэгт аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран ажиллаж, 2025 онд төвийн болон орон нутгийн нийт 65 албан хаагчдыг эрт илрүүлэг эрүүл мэндийн оношилгоонд бүрэн хамруулж дууссан. 2.1.2. Ажилтнуудын эрүүл мэндтэй холбоотойгоор 2025 оны эхний 05 дугаар сарын байдлаар төвийн 2 албан хаагч, орон нутгийн 1 албан хаагчдад 3-7 хоногийн цалинтай чөлөөг олгосон. 2.1.3. Байнгын асаргаа сувилгаа шаардагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нэг албан хаагч, 3 хүртэлх бага насны хүүхэдтэй нэг албан хаагчийн ажлын цагийг өдөрт 2 цагаар богиносгож ажиллуулж байна.	100
3	3.1. Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн гарын авлага, ном товхимолоор ажиллагсдыг хангах, плакат сурталчилгааны хуудсыг чийрэгжүүлэлтийн болон мэдээллийн самбарт байрлуулан сурталчилж байх, эмчийн анхан шатны тусламж үзүүлж байх	3.1.1. Ариун цэврийн өрөөний агааржуулалтын систем, суултуур, угаалтуур, ажлын өрөөг 2 цаг тутамд чийгтэй цэвэрлэгээ хийж байна. 3.1.2. Байгууллагын самбарт болон орон нутгийн станц харуулуудын мэдээллийн самбарт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх уриалга, зурагт хуудас, сурталчилгааны материалыг тогтмол байршуулж, мэдээ мэдээллийг цаг тухай бүр мэдээлж, заавар, зөвлөмжийг өгч байна.	100
4	4.1. Албан хаагчдад ажилдаа ирэх, буцах унааны зардлыг олгох.	4.1.1. Төвийн даргын 2024 оны 01 дугаар сарын 04-ний өдрийн А/02 тушаалаар төвийн албан хаагчдын унаа хоолны хөнгөлөлт хоногт 20,000 төгрөг, мөн орон нутгийн албан хаагчдад унаа хоолны хөнгөлөлтийг 10,000 төгрөгөөр тооцон олгож байна. Унаа хоолны зардал 05 дугаар сарын байдлаар нийт 66 албан хаагчид 91,344,500 төгрөгийг зарцуулаад байна. Мөн орон нутагт ажилласаны нэмэгдэл, ээлжийн техникчдийн шөнийн нэмэгдлийг тус тус тооцож олгож байна.	100
5	5.1. Албан хаагчдыг чийрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүр спорт зааланд тодорхой цаг авч, спортын арга хэмжээ зохион байгуулах.	5.1.1. Ажилчдыг чийрэгжүүлэх зорилгоор ЕБ-ын 2-р сургуультай гэрээ байгуулан тус сургуулийн спорт заалыг түрээслэж 7 хоногт нэг удаа 2 цагаар тоглож, ажилчдын дунд тэмцээн уралдаан зохион байгуулж байна. Мөн ажлын төв байранд цайны болон чөлөөт цагаараа дартс, ширээний теннис тоглох нөхцлийг бүрдүүлсэн.	100

1	2	3	4
6	6.1. Хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхижуулах.	6.1.1. Нийт ажилчдын суралцах, өөрийгөө хөгжүүлэх хүсэлтийг хүлээн авч бүхий л нөөцийг ашиглан гадаад, дотоод, аймаг орон нутагт зохион байгуулагдаж байгаа сургалтанд хамрагдахад дэмжин “Сургалтын төлөвлөгөө” боловсруулан хэрэгжүүлэн ажилласан. Байгууллагаас гадна болсон сургалт: 2025.03.27-ны өдөр Онцгой байдлын газраас “Газар хөдлөлтийн үеийн аюулгүй ажиллагаа” сэдэвт сургалт танхимаар 18 албан хаагч хамрагдав. 2025.04.09-ны өдрөөс 04.11-ний өдөр хүртэлх хугацаанд ЦУОШГ-аас зохион байгуулсан Удирдах ажилтны зөвлөгөөнд төвийн дарга хамрагдав. 2025.04.09-ны өдөр Музей сургалт судалгааны төвөөс “Музейгээр аялъя аян”-нд 5 албан хаагч хамрагдав. 2025.04.11-ний өдөр Хүнс,Хөдөө Аж ахуйн газраас зохион байгуулсан Газар тариалан эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөнд 1 албан хаагч хамрагдав. 2025.04.14-ний өдөр Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Хавдрын эсрэг үндэсний аян”-нд 2 албан хаагч хамрагдав. 2025.04.14-ний өдрөөс 04.16-ны өдөр хүртэлх хугацаанд ЦУОШГ-аас зохион байгуулсан “Тэсрэх бодис, тэсрэх материалтай харьцах ажилтны эрхийг сунгуулах сургалт”-нд танхимаар 2 албан хаагч хамрагдаж сертификат авсан. 2025.04.16-ны өдөр Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан Даатгуулагчийн нэгдсэн зөвлөгөөнд 3 албан хаагч хамрагдав. 2025.04.18-ны өдөр Байгаль орчны газраас зохион байгуулсан “Жендерийн эрх тэгш байдал” сэдэвт сургалтанд танхимаар 15 албан хаагч хамрагдав. 2025.04.28-ны өдрөөс 04.30-ны өдөр хүртэлх хугацаанд ЦУОШГ-аас Багаж хэмжил зүйн мэргэшүүлэх сургалтанд 1 албан хаагч хамрагдав. 2025.05.20-ны өдөр Аймгийн Архиваас Архив,албан хэрэг хөтлөлтийн сургалтанд 11 албан хаагч хамрагдав.	100

		2025.05.21-ний өдөр Дундговь аймагт зохион байгуулагдсан бүсийн зөвлөгөөн, сургалтанд 7 албан хаагч хамрагдсан. 2025.09.16-ний өдөр Онгой байдлын газраас зохион байгуулсан Гамгшгийн үеийн бэлэн байдал сургалтанд 21 албан хаагч хамрагдсан. Дотоодод явуулсан сургалт: 2025.03.20-ны өдрөөс 03.22-ний өдрүүдэд Орон нутгийн нэгдсэн сургалт семинар болж, нийт 50 ажилтан хамрагдсан. 2025.03.28-ны өдөр Эцэг эхийн зөвлөлөөс “Хүүхэд хамгааллын тухай хуулийн танилцуулга” сэдэвт сургалтанд танхимаар 28 албан хаагч хамрагдав. 2025.04.04-ны өдрөөс 05.02-ны өдөр хүртэлх хугацаанд Зангиа академийн Монгол бичгийн анхан шатны сургалтанд цахимаар 22 албан хаагч хамрагдав. 2025.05.19-ны өдөр Мэдээлэл үйлчилгээний хэлтсээс зохион байгуулсан Хос бичгийн сургалтанд 20 албан хаагч хамрагдав. 2025.05.19-ний өдрөөс 05.27-ны өдөр хүртэлх хугацаанд Байгаль орчны лабораторийн технологич инженерээр ажилд орох албан хаагчийг дадлагажуулж сургасан. Цаг уур орчны технологийн хэлтсээс 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу сар бүр станцын дарга, техникч нарт сургалт, хэлэлцүүлгийг явуулсан.	
7	7.1 Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийг тогтмол шуурхай дамжуулах, тэднийг мэдээллээр хангах зорилгоор “Мэдээллийн самбар” болон интернет дотоод сүлжээ, цахим хуудсуудаар тасралтгүй хангах.	7.1.1. Төв, орон нутгийн сүлжээ ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Төвийн сүлжээ нь Топнет ХХК-ны 8 тэрз хурдтай интернэтийн сүлжээг ашиглаж, мэдээ мэдээллийг дамжуулж байна. Орон нутгийн салбаруудад гэр интернет ашиглан шуурхай мэдээ, мэдээллийг дамжуулж байна. 7.1.2. Байгууллагын хэмжээнд "отодо7гmea!Бег.до7.тп, Ыотодо"ьпатет.до".тп, зьПеп.до".тп сайт хаягаар байгууллагын түүх, санхүү, хүний нөөцийн мэдээлэл, нээлттэй мэдээллийн ил тод байдал, хууль тогтоомж, дүрэм журам, цаг үеийн мэдээллийг тогтмол шинэчлэн мэдээлж байна. Мөн Цаг агаар, орчны мэдээ мэдээлэл пэйж хуудсаар мөн орон нутгийн ^8В телевизтэй хамтран цаг агаарын урьдчилсан болон аюулт, гамшигт үзэгдлээс сэрэмжүүлэх мэдээг цаг тухай бүрт нь олон нийтэд хүргэсэн.	100

1	2	3	4
8	8.1. Албан хаагчдын цалинг ажилласан жилийг харгалзан нэмэгдүүлэх, цол, эрдмийн зэрэг, мэргэшлийн зэрэг дэв, ур чадварын нэмэгдэл олгох	8.1.1. Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 04 сарын 21-ний өдрийн Мэргэшлийн зэрэг олгох тухай тушаалаар 1 инженер мэргэшлийн зэргийн шалгалт өгч мэргэшлийн 11-р зэргийн болзол хангасан. 8.1.2. УЦУОШТ-ийн даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” тушаалаар албан хаагчдад 25 хүртэлх хувиар ур чадварын нэмэгдлийг олгож байна. 8.1.3. Нийт батлагдсан орон тоо 66 бөгөөд 26 албан хаагч мэргэшлийн зэргийн нэмэгдэл авдаг. Үүнээс 15%-н мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 7 албан хаагч, 10%-н мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 17 албан хаагч, 20%-н мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 2 албан хаагч авч байна. 05 дугаар сарын байдлаар зэргийн нэмэгдэлд 20,433,400 төгрөгийн төсөв зарцуулагдсан байна. 8.1.4. Тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, мэргэжлийн тайлан, үнэлгээний дүнд үндэслэн ур чадварын нэмэгдлийг 05 дугаар сарын байдлаар 66 батлагдсан орон тооноос 52 албан хаагч авч байгаа бөгөөд 10%-25% хүртэлх хувиар олгож байна. Батлагдсан төсөвтөө багтаан ур чадварын нэмэгдэлд нийт 05 дугаар сарын байдлаар 44,550,600 төгрөгийн олгосон байна.	100
9	9.1. Орон нутагт томилолтоор ажиллах албан томилолтын зардлыг олгох	9.1.1. Тус байгууллагын дотоод албан томилолтын жилийн батлагдсан төсөв 16,650,000 төгрөг бөгөөд 2025 оны эхний 05 дугаар сарын байдлаар 32 албан хаагч албан ажлаар албан томилолт авсан байна. Үүнд хоолны зардалд 4,720,200 төгрөгийг зарцуулсан.	
1	2	3	4
10	10.1. Албан хаагчдын ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, амжилт гаргасан идэвхи зүтгэлийг үндэслэн төрийн дээд одон медаль болон бусад салбарын шагналаар шагнах, мөнгөн шагнал, эд зүйл дурсгах.	10.1.1. Тус байгууллагад үр бүтээлтэй олон жил ажилласан албан хаагчдыг БОУАӨЯ-ны “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 5 албан хаагч, БОУАӨЯ-ны “Хүндэт жуух бичиг”-ээр 1 албан хаагч, ЦУОшГ-ын даргын “Хүндэт жуух бичиг”-ээр 2 албан хаагч тус тус шагнагдсан.	100

1	2	3	4
11	11.1. Төрийн албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх	11.1.1. Т өвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/03 тоот “Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” тушаалын дагуу нийт 58 албан хаагчийн ээлжийн амралтын хуваарь батлагдсан бөгөөд үүнээс 2025 оны эхний 05 дугаар сарын байдлаар 18 албан хаагч ээлжийн амралтын хуудас авч амралтыг биеэр эдэлсэн.	100
12	12.1. Төрийн албан хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан заналхийлэх, доромжлох, гүтгэх, хүчирхийлэх болон бусад хууль бус үйлдлээс хамгаалах, авилга, хээл хахуульд өртөхгүй байлгах үүднээс сургалтын ажлыг зохион байгуулах	12.1.1. Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/07 дугаар тушаалаар “Эцэг эхийн зөвлөл” байгуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдийн хүүхдүүдийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрхийг нь хамгаалах, эцэг, эх асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх нийгэмд хүүхдийн эрхийг хамгаалах, эерэг хандлага төлөвшүүлэх зорилготойгоор ажиллаж байна. 12.1.2. Мөн байгууллагын зүгээс 1-р ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдэд үдийн цайны цагаар хүүхдээ хүргэж өгч авах боломжийг олгож ажиллаж байна. 12.1.3. Байгууллагын зүгээс 0-18 настай эцэг эхэд хүүхдийн төрсөн өдрөөр нь цалинтай чөлөө олгож ажиллаж байна. 12.1.4. Мөн 2025.03.28-ны өдөр Эцэг эхийн зөвлөлөөс “Хүүхэд хамгааллын тухай хуулийн танилцуулга” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 12.1.5. Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/08 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан бөгөөд албан хаагчдийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, нэг удаагийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх шатанд ажиллаж байна.	100
ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ДУНДАЖ /%-аар/			100

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ч.АМАРЦЭНГЭЛ